



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2021 оны 06 сарын 11 өдөр

Дугаар 251

Улаанбаатар хот

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах
үйл ажиллагаа эрхлэх тусгай
зөвшөөрөл олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.2.6, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 15 дугаар зүйлийн 15.3.6, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.3, 12 дугаар зүйлийн 12.5, Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3, 10 дугаар зүйлийн 10.5, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 32 дугаар тогтоолоор баталсан “Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлын үед санхүү, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн үйлчилгээнд цахим шилжилт хийх арга хэмжээ”-ний 6.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Носк гурав” ХХК-д хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг тус компанийн гаргаж буй үл хөдлөх хөрөнгийн түрээсийн орлогоор баталгаажсан үнэт цаасны төлбөрийг гүйцэтгэх эцсийн хугацаанаас багагүй хугацаагаар олгосугай.

2. Энэ тогтоолын 1-д заасан тусгай зөвшөөрлийг олгосонтой холбогдуулан компанийн эрхлэх үйл ажиллагааны төрөл болон оноосон нэрд өөрчлөлт оруулж, Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэн энэ тухай Санхүүгийн зохицуулах хороонд ажлын 15 хоногийн дотор мэдэгдэхийг “Носк гурав” ХХК /Б.Энхдалай/-д үүрэг болгосугай.

3. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгож байгаатай холбогдуулан “Носк гурав” ХХК /Б.Энхдалай/ болон “Нийслэлийн орон сууцны корпораци” ХК /М.Говьсайхан/-д дараах арга хэмжээ авч ажиллахыг үүрэг болгосугай:

1/ Хөрөнгө оруулагчид, харилцагчдын хууль ёсны эрх ашгийг хамгаалж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлэх;

2/ Санхүүгийн зохицуулах хорооны холбогдох журамд заасан мэдээллийг цаг тухайд нь тогтмол ирүүлэх.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

